

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-13</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>14-28</i>
<hr/>	
1. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	15-16
2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	16-17
3. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	17-24
4. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	24-24
5. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	25-27
6. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	27-28

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 04-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Ё.Баатарбилэг, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал, Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Н.Энхболд: “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршил” гэсэн хүснэгтийн “Сумын нэр” багана дахь “Төв аймгийн Сэргэлэн сум” мөрөнд хамаарах хэсгийг бүхэлд нь хасаж, үүнтэй уялдуулан мөн

хүснэгтийн “Сумын нэр” багана дахь “Нийт” гэсэн мөрний “32,501.3” гэснийг болон тогтоолын төслийн 2 дахь заалтын “32,501.3 га” гэснийг “31,501.3” гэж, 1 дэх заалтын “тогтвортой хөгжлийн зорилгод” гэснийг “хөгжлийн бодлогын баримт бичигт” гэж, 4 дэх заалтын ““эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилгод нийцүүлэн хөгжүүлэх” гэж” гэснийг ““эдийн засгийн тодорхой салбаруудыг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн хөгжүүлэх” гэж” гэж, “2,3 дахь” гэснийг “2 дахь” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, Барилга, хот байгуулалтын

яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн үндэсний хорооны ахлах мэргэжилтэн М.Буяндэлгэр, Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн асан, Техникийн ухааны доктор Н.Тогтох, Монгол Улсын Их сургуулийн профессор, Шинжлэх ухааны доктор Р.Ринчинбазар, “Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэг”-ийн захирал Д.Пүрэвбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг зүйл бүрээр үргэлжлүүлэн хэлэлцэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн асан, Техникийн ухааны доктор Н.Тогтох Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсгийн “долоон” гэснийг хасаж, мөн хэсгийн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсыг эдийн засгийн” гэснийг “Монгол Улсыг” гэж, мөн хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг “Бүсүүдэд дараах аймаг, хотууд хамаарна” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн “Монгол Улсын бүсчлэлтэй уялдуулан” гэснийг, мөн хэсгийн “уян хатан” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн “тогтоож,” гэснийг “тогтоох бөгөөд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.1 дэх заалтын “Улаанбаатар хотын засаглалын” гэснийг, 3.7.25 дахь

хэсгийн “50.0 тн багтаамжтай” гэснийг, 3.7.27 дахь заалтын “5” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.2 дахь заалтын “Төрийн” гэсний дараа “зарим” гэж, 3.7.28 дахь заалтын “шинэчилж” гэсний өмнө “олон улсын стандартад нийцүүлэн” гэж нэмж, 3.5.3 дахь заалтын “тахилгат хайрхан уулс, хүн чулуун хөрөгт” гэснийг “байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.17 дахь заалтын “3.6 сая” гэснийг “5.4 сая” гэж, 3.2.6 дахь заалтын “4.2 сая” гэснийг “5.8 сая” гэж, 3.3.10 дахь “1.5 сая” гэснийг “3.1 сая” гэж, 3.4.10 дахь заалтын “672.4 мянган” гэснийг “1.5 сая” гэж, 3.5.10 дахь “1.7 сая” гэснийг “3.0 сая” гэж, 3.6.13 дахь “2.2 сая” гэснийг “3.0 сая” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсгийн “дараах үе шатаар-хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал, төсөл хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, эрэмбэтэй уялдуулан тухай бүр тодотгол хийж болно.” гэснийг “дараах үе шаттай хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, мөн хэсгийн “(2041-2050 он хүртэлх)” гэсний дараах “гэсэн үе шатаар хэрэгжүүлнэ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 5.1 дэх хэсгийн “удирдах,” гэснийг, 6.1.3 дахь хэсгийг бүхэлд нь хасаж, 6.1 дэх хэсгийн “Төрөөс бүсчилсэн хөгжлийн бодлого” гэснийг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” хэсгийн “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал” гэж, “Хэмжих нэгж” баганад “МВт” гэж, “2030” баганад “30” гэж, “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганад “Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.” гэж, “Мэдээллийн эх үүсвэр” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд, “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2030” гэсэн баганын “330” гэснийг “44” гэж, “2050” гэсэн баганын “642” гэснийг “0” гэж, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2050” баганад харгалзах “386” гэснийг “40” гэж, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2050” гэсэн баганын “487” гэснийг “394” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2030” гэсэн баганын “471” гэснийг “752” гэж, “2040” гэсэн баганын “834” гэснийг “645” гэж, “2050” гэсэн баганын “525” гэснийг “0” гэж, мөн хэсгийн “Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо” гэсэн мөрний “2040” гэсэн баганын “1” гэснийг “2” гэж, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганын “464” гэснийг “685” гэж, “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн хэсгийн “2040” гэсэн баганын “145” гэснийг “249” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “3.Хойд бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганад харгалзах хэсэгт “166” гэж, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганад “116” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн хэсгийн “2050” гэсэн баганад “218” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4

Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн “Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, мөн дээрх бүсүүд болон “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр логистикийн төв” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” гэсэн баганын “Засгийн газар” гэснийг “Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, 2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Шинээр байгуулагдах” гэсний дараа “хүнд үйлдвэрийн” гэж нэмж, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн мөн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэсэн мөрөнд “Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэж харгалзах мөрөнд нийцүүлж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Цахилгаан дамжуулах шугамын урт” гэсэн мөрний “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганын “Цахилгаан станц, шугамын дамжуулах чадвар нэмэгдсэн байна.” гэснийг “Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын уртын хэмжээ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “Суурь түвшин” баганын “10.9” гэснийг “3.8” гэж, “2030” гэсэн баганын “3.6” гэснийг “3.8” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “14.5” гэснийг “12.6” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “4.5” гэснийг “3.8” гэж, “2040” гэсэн баганын “0.5” гэснийг, “2050” гэсэн баганын “0.3” гэснийг “0.8” гэж тус тус, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “2.8” гэснийг “1.8” гэж, “2030” гэсэн баганын “0.5” гэснийг “0.6” гэж, “2040” гэсэн баганын “0.7” гэснийг, “2050” гэсэн баганын “0.1” гэснийг “0.5” гэж тус тус, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “6.4” гэснийг “5.1” гэж, “2030” гэсэн баганын “1.7” гэснийг “1.4” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “6.2” гэснийг “5.7” гэж, “2030” гэсэн баганын “1.5” гэснийг “2.4” гэж, “2040” гэсэн баганын “0.7” гэснийг, “2050” гэсэн баганын “0.9” гэснийг “0.3” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 12

58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.27.Цэцэрлэг хот- Баянхонгор хот чиглэлийн авто зам барина” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 7
Бүгд: 12
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.2 Евроазийг дөтөөр холбох ОХУ-ын Москва Казанийн өндөр хурдын авто замыг үргэлжлүүлэн Монголоор дайруулан Бүгд найрамдах Хятад улстай холбох санаачилгыг дэмжиж Красноярск, Арцсуурь, Шивээ хүрэн боомтын чиглэлээр дамжин өнгөрүүлнэ.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн хүснэгтийн “татагдах” гэснийг “таталцах” гэж, “Турав.Бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилтууд” бүлгийн “Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго нь” хэсгийн “үндэслэж” гэснийг “үндэслэнэ” гэж, “илрүүлж” гэснийг “илрүүлнэ” гэж, “тодорхойлж” гэснийг “тодорхойлно” гэж, “сэргээж” гэснийг “сэргээнэ” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “нэвтрүүлж” гэснийг “нэвтрүүлнэ” гэж, “хэрэгжүүлж” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж тус тус, “хуваарилж” гэснийг “хуваарилна” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “хөгжүүлж” гэснийг “хөгжүүлнэ” гэж, “байгуулж” гэснийг “байгуулна” гэж тус тус, “тэлж” гэснийг “тэлнэ” гэж, “бууруулж” гэснийг “бууруулна” гэж, мөн хэсгийн “хөгжүүлнэ” гэснийг өмнөх “бүс нутгийг” гэснийг “бүсүүдийг” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.3.Хойд бүс” гэсэн хэсгийн, 3.4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “3.6.Говийн бүс” гэсэн хэсгийн зорилгын “нутаг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа нарын 4 гишүүн 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 11 цаг 30 минутад түр завсарлаж, 13 цаг 48 минутаас үргэлжлэв.

Тав.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Энхболд: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.5-7.7 дахь хэсэг:

“7.5.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу баригдсан нийтийн номын сан, ахмадын төв, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, боловсрол, соёлын болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай, олон улсын стандартад нийцсэн барилга, байгууламжид ногдох үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглалтад оруулах шийдвэр гарснаас хойш эхний 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

7.7.Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.5 дахь хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Баярмаа, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Б.Төрбат, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Баялагцэнгэл, Нийслэлийн захирагчийн Ажлын албаны төлөвлөлт хариуцсан шинжээч Ц.Батгэрэл, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны Ерөнхий менежер Б.Гүнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Баярмаа, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Н.Учрал танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Н.Энхболд: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн *ирцтэйгээр* 14 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим, 10 цаг 34 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцэд орсон гишүүд танхимдаа ирье. Хурлаа эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлуудаа танилцуулъя.

1 дүгээрт. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн төслүүд /Засгийн газар 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ хийнэ.

2 дугаарт Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ганболд нарын 6 гишүүн 2024 оны 5 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ хийнэ.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газраас 5 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүнээс 2023 оны 6

сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

4 дүгээрт Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /эцсийн хэлэлцүүлэг, Засгийн газар 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулж боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ хийнэ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед түрүүчийн хуулиудтай нь уялдуулаад ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байна гэсэн учраас боловсруулж оруулж байгаа ийм хуулийн төслүүд байна.

Бусад гээд 7 дугаарт хийчихье. Бусад асуудлыг хуралдааны явцад хоорондоо холбоотой юмнууд байгаа юм. Тэгээд хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгийг танилцуулъя.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл олон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэхэд оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн. Нийслэлийн Засан дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан 1 дүгээр орлогч Сайнзориг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын шинжээч Төрбат, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Хотын захирагчийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга Амгалан, Барилга, хот байгуулалтын яамны Хөгжлийн бодлого

төлөвлөлт, хот байгуулалтын газрын ахлах шинжээч Билэгсайхан, Хан-Уул дүүргийн Засаг дарга Алдаржавхлан, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал эрхэлсэн захиргааны дарга Батбаяр, мөн захиргааны ерөнхий менежер Гүнболд, Нийслэлийн хотын авто замын түгжрэлийг бууруулах хорооны ажлын албаны төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч Батгэрэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Баялагцэнгэл, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын мэргэжилтэн Энхжаргал, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн Уранбилэг нар оролцож байна. Ажлын хэсгийнхнийг дуудъя. Ажлын хэсгийн ахлагч Учрал сайдыг дуудъя.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль төсөл хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн ажлын хэсгийн танилцуулгыг Мөнхцэцэг гишүүн хийнэ.

Танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагч өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 1 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл зарчмын зөрүүтэй санал болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа. Эцсийн хэлэлцүүлэгт зарчмын зөрүүтэй 1 саналын томъёолол орж ирсэн. Төрийн байгуулалтын байнгын

хорооноос ажлын хэсгийн санал байр суурийг үндэслээд. Би томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу хураалгах зарчмын зөрүүтэй санал. Нэгдсэн чуулганы хуралдаан дээр санал хураагаагүй, гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Түүний дагуу боловсруулж байгаа ийм санал байгаа.

Нэг. “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтын “Шинэ Зуунмод хотын эдэлбэр газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээ, байршил” гэсэн хүснэгтийн “Сумын нэр” багана дахь “Төв аймгийн Сэргэлэн сум” мөрөнд хамаарах хэсгийг бүхэлд нь хасаж, үүнтэй уялдуулан мөн хүснэгтийн “Сумын нэр” багана дахь “Нийт” гэсэн мөрний “32,501.3” гэснийг болон тогтоолын төслийн 2 дахь заалтын “32,501.3 га” гэснийг “31,501.3” гэж, 1 дэх заалтын “тогтвортой хөгжлийн зорилтод” гэснийг “хөгжлийн бодлогын баримт бичигт” гэж, 4 дэх заалтын ““эдийн засгийн тодорхой салбаруудыг тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн хөгжүүлэх” гэж” гэснийг ““эдийн засгийн тодорхой салбаруудыг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн хөгжүүлэх” гэж” гэж, “2,3 дахь” гэснийг “2 дахь” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Энэ томъёоллоор санал хураалт хийе. Санал хураалт. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 11 гишүүн оролцож, 9 нь дэмжиж, 81,8 хувиар саяын саналыг дэмжлээ.

Ажлын хэсгээс боловсруулсан Байнгын хорооноос боловсруулсан зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж дууслаа.

Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл хамт

өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Мөнхцэцэг гишүүн танилцуулна.

10.43 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа. Их Хурлын гишүүн Ганболд нарын 6 гишүүнээс 2024 оны 5 сарын 17-ны өдөр Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Их хурал 2024 оны 5 сарын 31-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд илгээжүүлсэн байгаа.

Байнгын хороо 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж байна. Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг нэмж тусгаад, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Хэлэлцээж ишийдвэрлэж өгөхийг хүсье.

Танилцуулгатай холбоотой асуух гишүүд байна уу. Алга байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг Оюунчимэг гишүүн байхгүй байна уу. Байхгүй бол Сарангэрэл гишүүн, Жаргалмаа гишүүн.

10.44 цаг.

Дараагийн асуудалдаа орёё.

“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Дараагийн ажлын хэсгээ оруулъя. Яах вэ. Яах вэ та хэд байж л бай хүчин хөгжил нь орж ирнэ шүү дээ. Одоо баахан зарчмын зөрүүтэй санал ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүдийг дуудаарай. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Цогтгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Нийслэлийн Засаг даргын орлогч Сайнзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Балчинлуvsан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан, Эрчим хүчний яамны газрын дарга Ерэн-Өлзий, Зам, тээвэр хөгжлийн яамны газрын дарга Болор-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны газрын дарга Цэрэндулам, Барилгын хөгжлийн төвийн Хот байгуулалт зураг төслийн институтын эрхлэгч Одбаяр, Техникийн ухааны доктор, Улсын Их Хурлын гишүүн асан Тогтох, Монгол

Улсын Их Сургуулийн профессор, Шинжлэх ухааны доктор Ренчинбазар, Эрчим хүчний хөгжлийн төлөө Монголын нийгэмлэгийн захирал Пүрэвбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах шинжээч Мөнхжаргал, Зам, тээвэр хөгжлийн яамны шинжээч Батцэцэг, Соёлын яамны хэлтсийн дарга Батхуяг, Барилга, хот байгуулалтын яамны газрын дарга Батболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны газрын дарга Оюунаа, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны газрын дарга Сүхбат, Хот, хөдөөгийн сэргэлт, Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хорооны ахлах мэргэжилтэн Буяндэлгэр, Эрүүл мэндийн яамны газрын дарга Оюунцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Мөнхнасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга Дондогдорж, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн яамны шинжээч Болдбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ахлах шинжээч Эрдэнэцэцэг, Сангийн яамны газрын дарга Золбоо, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны ахлах шинжээч Эрдэнэ, Эрчим хүчний яамны ахлах шинжээч Энхтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны ахлах мэргэжилтэн Чулуунчимэг, Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн захирал, доктор, профессор Баттүвшин нар ажлын хэсэгт ирсэн оролцож байгаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд ажилласан. Их Хурлаас ажлын дэд хэсэг ажилласан байгаа. Нэгдсэн чуулганы хуралдааны дараа тусгайлан ажлын хэсэг гараагүй учраас санаачлаад зарчмын зөрүүтэй саналууд энэ үзэл баримтлалын баримт бичигт оруулахаар би бэлтгэсэн. Энэ саналуудын томъёоллыг гишүүдэд тараасан байгаа. Тэгэхдээ холбогдох яамны хүмүүстэй ажлын хэсгийн шугамаар санал солилцсон гэж ойлгож байгаа. Ингээд санал хураалтаа явуулъя.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд.

Энэ саналуудыг боловсруулахдаа Засгийн газраас оруулж ирсэн тогтоолын төслийн хавсралтуудтай гол төлөв ихэнх зүйлүүдийг нь нэгтгэж уялдуулж өөрчилсөн ийм саналууд байгаа шүү. Шалгуур үзүүлэлтүүдийн хүрэх түвшнийг нь бичиж оруулж ирэхдээ бас Засгийн газраас наана цаана бичсэн алдаатай юмнууд байсан байна лээ. Эдгээрийг засаж Засгийн газраас оруулж ирсэн хавсралтууд заасан хүрэх түвшнүүдтэй нь гол төлөв уялдуулж нийцүүлж оруулсан ийм зарчмын зөрүүтэй саналууд байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Ингээд санал хураалтаа явуулж эхэлнэ.

1.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсгийн “долоон” гэснийг хасаж, мөн хэсгийн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэглүүр болгон Монгол Улсыг эдийн засгийн” гэснийг “Монгол Улсыг” гэж, мөн хэсгийн хоёр дахь өгүүлбэрийг “Бүсүүдэд дараах аймаг, хотууд хамаарна” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт гишүүд ээ. 11-ээс 7 дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдэж байна.

2.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн “Монгол Улсын бүсчлэлтэй уялдуулан” гэснийг, мөн хэсгийн “уян хатан” гэснийг тус тус хасаж, мөн хэсгийн “тогтоож,” гэснийг “тогтоох бөгөөд” гэж өөрчлөх. Санал хураалт. 11-ээс 8 дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

3.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.1 дэх заалтын “Улаанбаатар хотын засаглалын” гэснийг, 3.7.25 дахь хэсгийн “50.0 тн

багтаамжтай” гэснийг, 3.7.27 дахь заалтын “5” гэснийг тус тус хасах. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт 11-ээс 7 дэмжиж, 63,6 хувиар саналыг дэмжиж байна.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.4.2 дахь заалтын “Төрийн” гэсний дараа “зарим” гэж, 3.7.28 дахь заалтын “шинэчилж” гэсний өмнө “олон улсын стандартад нийцүүлэн” гэж нэмж, 3.5.3 дахь заалтын “тахилгат хайрхан уулс, хүн чулуун хөрөгт” гэснийг “байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлд” гэж өөрчлөх. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор явуулъя. 11-ээс 8 дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 3.1.17 дахь заалтын “3.6 сая” гэснийг “5.4 сая” гэж, 3.2.6 дахь заалтын “4.2 сая” гэснийг “5.8 сая” гэж, 3.3.10 дахь “1.5 сая” гэснийг “3.1 сая” гэж, 3.4.10 дахь заалтын “672.4 мянган” гэснийг “1.5 сая” гэж, 3.5.10 дахь “1.7 сая” гэснийг “3.0 сая” гэж, 3.6.13 дахь “2.2 сая” гэснийг “3.0 сая” гэж өөрчлөх.

Түрүүн хэлсэн. Засгаас орж ирсэн тогтоолын хавсралттайгаа уялдуулж өөрчилж байгаа тоонууд шүү. Санал хураалт явуулъя. Дэмжье. 11-ээс 8 дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

6.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсгийн “дараах үе шатаар—хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал, төсөл хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, эрэмбэтэй уялдуулан тухай бүр тодотгол хийж болно.” гэснийг “дараах үе шаттай хэрэгжүүлнэ:” гэж өөрчилж, мөн хэсгийн “(2041-2050 он хүртэлх)” гэсний дараах “гэсэн үе шатаар хэрэгжүүлнэ” гэснийг хасах. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 11-ээс 8 дэмжиж, 72,7 хувиар санал дэмжигдэж байна.

7.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 5.1 дэх хэсгийн “удирдах,” гэснийг, 6.1.3 дахь хэсгийг бүхэлд нь хасаж, 6.1 дэх хэсгийн “Төрөөс бүсчилсэн хөгжлийн бодлого” гэснийг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг” гэж өөрчлөх. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт 11-ээс 8 дэмжсэн байна. 72,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

8.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” хэсгийн “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр нэмэгдэх эрчим хүчний эх үүсвэр, хүчин чадал” гэж, “Хэмжих нэгж” баганад “МВт” гэж, “2030” баганад “30” гэж, “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганад “Эрчим хүчний нэгдсэн систем гэдэгт 110кВ-оос дээш хүчдэлийн түвшинтэй шугам, дэд станц болон түүнд холбогдсон цахилгаан станцуудыг ойлгоно.” гэж, “Мэдээллийн эх үүсвэр” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жилд нэг удаа” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж нэмэх. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Энэ Засгийн газраас оруулж ирсэн материал дотроо зарим газар зүгээр Засгийн газар гээд биччихсэн. Зарим газраа хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гээд биччихсэн байсан юмнуудыг бид нар бүгдийг нь жигдэлсэн байгаа шүү. Төрийн захиргааны төв байгууллага гэж өөрчилсөн байж байгаа. 11-ээс 6, 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байгаарай Тогтохсүрэн гишүүн, Ганболд гишүүн санал хураалт.

9.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн

захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд, “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2030” гэсэн баганын “330” гэснийг “44” гэж, “2050” гэсэн баганын “642” гэснийг “0” гэж, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2050” баганад харгалзах “386” гэснийг “40” гэж, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2050” гэсэн баганын “487” гэснийг “394” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2030” гэсэн баганын “471” гэснийг “752” гэж, “2040” гэсэн баганын “834” гэснийг “645” гэж, “2050” гэсэн баганын “525” гэснийг “0” гэж, мөн хэсгийн “Хүчин чадал нэмэгдсэн боомтын тоо” гэсэн мөрний “2040” гэсэн баганын “1” гэснийг “2” гэж, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганын “464” гэснийг “685” гэж, “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн хэсгийн “2040” гэсэн баганын “145” гэснийг “249” гэж өөрчлөх. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Санал хураалт Ганболд гишүүн ээ. 12-оос 8 дэмжсэн байна. 66,7 хувиар санал дэмжигдэж байна.

10.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “3.Хойд бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганад харгалзах хэсэгт “166” гэж, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах төмөр замын урт” гэсэн мөрний “2040” гэсэн баганад “116” гэж, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн “Шинээр баригдах улсын чанартай автозамын урт” гэсэн хэсгийн “2050” гэсэн баганад “218” гэж нэмэх. Саналыг дэмжье. Санал хураалт. 12 Гишүүнээс 8 дэмжиж, 66,7 хувиар санал дэмжигдлээ.

11.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн “Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, мөн дээрх бүсүүд болон “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ, тээвэр логистикийн төв” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” гэсэн баганын “Засгийн газар” гэснийг “Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус, 2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Хариуцах байгууллага” баганын “Засгийн газар” гэснийг “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчлөх. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ. 12-оос 7 дэмжсэн байна. 58,3 хувиар дэмжигдлээ.

12.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэсэн мөрний “Шинээр байгуулагдах” гэсний дараа “хүнд үйлдвэрийн” гэж нэмж, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн мөн “Шинээр байгуулагдах үйлдвэрлэл

технологийн паркийн тоо” гэсэн мөрөнд “Шинээр байгуулагдах хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн тоо” гэж харгалзах мөрөнд нийцүүлж нэмэх. Саналыг дэмжье. Санал хураалт. 12-оос 6 дэмжиж, 50 хувиар санал дэмжигдсэн байна. Гишүүд анхааралтай оролцоорой. Өө энэ уначихсан байна. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Уучлаарай сая нөгөө санал хураалтад анхаарал сарниад санал хураалтад орж чадсангүй. Дэмжиж байгаа. Би дахин санал хураалгая.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтын дүнг хүчингүй болгож түрүүчийн томьёоллоор дахин санал хураалт явуулъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. 12-оос 7 дэмжиж, 58,3 хувиар уг санал дэмжигдэж байна. Түрүүчийн 12 дугаар саналын томьёоллыг уншсан байгаа. Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт. Түрүүчийн санал хүчингүй болсон. Дахин санал хураалт явуулж байна. 12-оос 7 дэмжиж, 58,3 хувиар санал дэмжигдлээ.

13.Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн, “7.Улаанбаатарын бүс” гэсэн хэсгийн “Цахилгаан дамжуулах шугамын урт” гэсэн мөрний “Шалгуур үзүүлэлтийн тайлбар” баганын “Цахилгаан станц, шугамын дамжуулах чадвар нэмэгдсэн байна.” гэснийг “Шинээр барих цахилгаан дамжуулах шугамын уртын хэмжээ” гэж өөрчлөх. Санал хураалт дэмжье гэсэн санал хураалт явуулж байна. 12-оос 7 дэмжсэн байна. 58,3 хувиар санал дэмжигдлээ.

14. Тогтоолын төслийн 2 дугаар хавсралтын “1.Хангайн бүс” гэсэн хэсгийн “Тусгай хамгаалалтад авсан

газар нутгийн хэмжээ” гэсэн мөрний “Суурь түвшин” баганын “10.9” гэснийг “3.8” гэж, “2030” гэсэн баганын “3.6” гэснийг “3.8” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “2.Баруун бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “14.5” гэснийг “12.6” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “3.Хойд бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “4.5” гэснийг “3.8” гэж, “2040” гэсэн баганын “0.5” гэснийг, “2050” гэсэн баганын “0.3” гэснийг “0.8” гэж тус тус, “4.Төвийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “2.8” гэснийг “1.8” гэж, “2030” гэсэн баганын “0.5” гэснийг “0.6” гэж, “2040” гэсэн баганын “0.7” гэснийг, “2050” гэсэн баганын “0.1” гэснийг “0.5” гэж тус тус, “5.Зүүн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “6.4” гэснийг “5.1” гэж, “2030” гэсэн баганын “1.7” гэснийг “1.4” гэж, “2040” гэсэн баганын, “2050” гэсэн баганын “1.0” гэснийг “0.8” гэж тус тус, “6.Говийн бүс” гэсэн хэсгийн мөн мөрний “Суурь түвшин” баганын “6.2” гэснийг “5.7” гэж, “2030” гэсэн баганын “1.5” гэснийг “2.4” гэж, “2040” гэсэн баганын “0.7” гэснийг, “2050” гэсэн баганын “0.9” гэснийг “0.3” гэж тус тус өөрчлөх. Саналыг дэмжье. Санал хураалт. 12 гишүүнээс 7 дэмжсэн байна. 58,3-аар санал дэмжигдлээ.

15.Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“3.1.27.Цэцэрлэг хот- Баянхонгор хот чиглэлийн авто зам барина”

Энэ чинь цоо шинэ юм орж ирж байгаа юм уу. Эсвэл нөгөө хавсралтдаа юм үлдсэн юм уу. Ажлын хэсгээс хариулах хүн байна уу. 5 номер хариулах уу.

Цэцэрлэг хот-Баянхонгор хот чиглэлийн авто зам барина гэсэн шинэ

заалт нэмж байгаа юм байна. 7 номер. Албан тушаал албан тушаал нэрээ хэлээд.

Б.Болор-Эрдэнэ: Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар Болор-Эрдэнэ байна. Архангай-Баянхонгорын чиглэлийн замын хувьд бол эдийн засгийн ач холбогдолтой бүсийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тээврийн дэд бүтцийн хөгжлийг хангахад нөлөөтэй чухал зам гэж бид үзэж байгаа. Энийг бол яамны зүгээс дэмжиж байгаа.

Н.Энхболд: Засгийн газраас оруулж ирсэн санал дотор байхгүй байсан юм уу.

Б.Болор-Эрдэнэ: Байхгүй байсан юм. Тэгээд энийг бол бид нар нэмж хэлэлцээд, ажлын хэсэг дээр гарсан саналын дагуу бол бид нар дэмжиж байгаа.

Н.Энхболд: Хэдээс хэдэн оны хугацааны юм байгаа юм.

Б.Болор-Эрдэнэ: 2030-2040 оны хооронд.

Н.Энхболд: Ганболд гишүүн.

Г.Ганболд: Ажлын хэсгийнхэн ингээд өөрсдөө санал оруулаад ороод ирж болох юм уу. Хэрэв нэгэнт оруулж ирээд дэмжих гэж байгаа бол сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбоотой, бас энэ Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөртэй холбоотой, Хангайн бүсийн ерөөсөө хамгийн гол хөгжлийн зам бол энэ зам байгаа шүү дээ. Тэгэхээр энэ замын асуудлыг бүр 2024-2030 он, 2030 он хүртэл гэж байгаа юм уу дарга аа. Хугацаа дээр.

Н.Энхболд: Он нь алга байна.

Г.Ганболд: 2024-2028 оны хооронд гэсэн хугацаагаар оруулах санал гаргаж болох юм уу дарга аа. Тэгвэл зарчмын

зөрүүтэй санал гаргаад би санал хураалгачихъя.

Н.Энхболд: Тэгэхээр ингэе. Энэ саналаа хураачхаад дэмжигдвэл нөгөө онууд тавьсан хэсэг байгаа шүү дээ. Тэр дээр нэмээд оруулчихъя. Тэгэх үү. Тийм тайлбартайгаар саяын “Цэцэрлэг хот-Баянхонгор хот чиглэлийн авто зам барина” гэснийг санал хураалт явуулъя. Дэмжигдвэл саяын хэлсэн оноор хавсралт дээр оныг нь тавина гэж ойлголцоод явъя. Санал хураалт гишүүд ээ. Уначихлаа. Яах юм. Орхилоо шүү тэгвэл. Бямбацогт гишүүн, Жаргалмаа гишүүн санал гаргая. Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Сая кнопдоо хүрч чадсангүй. Уг нь дэмжье гэж бодож байсан. Горимын саналаар хүчингүй болгож өгч, дахиж санал хураалгаж өгнө үү.

Н.Энхболд: Саяын санал хураалтын дүнг хүчингүй болгох Бямбацогт гишүүнийг горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал уначихлаа. Хуучнаараа үлдлээ дээ. Өгсөн байна. Саяын нэрийг нэрсийг гаргаадах. Санал гаргах юм уу. Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Уг нь Ганболд гишүүн асуулт асуусан л даа. Яагаад 2030 он гэж заасан юм бэ. Уг нь түүнд л хариулт авчихвал би саналаа өгмөөр байх юм. Асуултад хариулаагүй учраас миний санал дарагдахгүй байна л даа.

Н.Энхболд: Тэгээд тоог нь ингэсэн юм. Тэндээс тайлбар ирээгүй. Тэгээд сая ярьж байгаад 2024-2028 онд болгоё гэсэн агуулгаар хураагаад энэ санал дэмжигдвэл нөгөө багана дээр нь оныг нь тавья гээд ярьсан юм.

Б.Жаргалмаа: Тэгвэл саяын саналыг хүчингүйд тооцож санал хурааж өгнө үү. Би тайлбар аваагүй учраас дахин тайлбар авах гээд.

Н.Энхболд: Жаргалмаа гишүүн тайлбар аваад, горимын санал гаргалаа. Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12-оос 7 дэмжиж, санал хүчингүй боллоо.

Одоо түрүүчийн томъёоллоороо тайлбартайгаа санал хураагаад чуулганд орохдоо тэр багана дээр нь оныг нь бичсэн байх хэрэгтэй болох нь байна шүү. Бараг зарчим зөрүүтэй санал болох байх. Түрүүчийн томъёоллоор ойлголтоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 11-ээс 7 дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсгийн хүснэгтийн “татагдах” гэснийг “талалцах” гэж, “Гурав.Бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилтууд” бүлгийн “Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго нь” хэсгийн “үндэслэж” гэснийг “үндэслэнэ” гэж, “илрүүлж” гэснийг “илрүүлнэ” гэж, “тодорхойлж” гэснийг “тодорхойлно” гэж, “сэргээж” гэснийг “сэргээнэ” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “нэвтрүүлж” гэснийг “нэвтрүүлнэ” гэж, “хэрэгжүүлж” гэснийг “хэрэгжүүлнэ” гэж тус тус, “хуваарилж” гэснийг “хуваарилна” гэж, “дэмжиж” гэснийг “дэмжинэ” гэж, “хөгжүүлж” гэснийг “хөгжүүлнэ” гэж, “байгуулж” гэснийг “байгуулна” гэж тус тус, “тэлж” гэснийг “тэлнэ” гэж, “бууруулж” гэснийг “бууруулна” гэж, мөн хэсгийн “хөгжүүлнэ” гэсний өмнөх “бүс нутгийг” гэснийг “бүсүүдийг” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын “3.2.Баруун бүс” гэсэн хэсгийн, “3.3.Хойд бүс” гэсэн хэсгийн, “3.4.Төвийн бүс” гэсэн хэсгийн, “3.6.Говийн бүс” гэсэн хэсгийн зорилгын “нутаг” гэснийг тус тус хасах. Найруулгын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт 11-ээс 6,

дэмжиж 54,5 хувиар саяын санал дэмжигдлээ.

Цэрэнпунцаг гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналууд байгаа танилцуулъя.

Төслийн 1 дүгээр хавсралтад “3.2.2 Евроазийг дөтөөр холбох ОХУ-ын Москва Казанийн өндөр хурдын авто замыг үргэлжлүүлэн Монголоор дайруулан Бүгд найрамдах Хятад улстай холбох санаачилгыг дэмжиж, Красноярск, Арцсуурь, Шивээ хүрэн боомтын чиглэлээр дамжин өнгөрүүлнэ.” гэж нэмэх болно. Тэгэхдээ энэ ингээж гадаад улс орнуудын хотын нэрүүд, тэр замыг нь тусгайлан нэрлэх зам байна уу. Хэрэггүй байна уу. Хэрвээ ингэнэ гэж бодвол өөрийн улсын боомт хүртэлх замынхаа нэрийг нэрлээд саналынхаа тайлбар дээр цаана цаана нь ийм санаа байгаа юм гэдгээ хэлсэн нь зүйтэй байх. Цэрэнпунцаг гишүүнд микрофоныг нь өгье. Та картаа хийсэн үү.

Ц.Цэрэнпунцаг: Энхболд даргын хэлдэг санаа бол бас зөв байх. Цаад агуулга нь бол энэ саяын хэлдэг энэ гадаадын хурдны замыг бол цааш нь үргэлжлүүлж холбоно гэсэн ийм агуулга санаа байгаа юм. Ер нь бол энэ Алсын хараа 2050 дээр байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ миний бодлоор саналынхаа томъёоллыг Арцсууриасаа Шивээ хүрэн боомтын чиглэлээр дамжуулан өнгөрүүлнэ. Энэ 2-ыг холбосон олон улсын хурдны замын нэг хэсэг байна гэсэн ийм агуулгаар саналынхаа томъёололыг өөрчилж бичээд протоколдоо оруулчих уу. Тэгээд энийг та бүхэн дэмжиж өгөөч ээ. Энэ бол 2050-д орсон ийм зам байгаа юм шүү. Тийм учраас та бүхэн энийг дэмжээд өгөөрэй гэж байгаа юм. Өнөөдрийн эдийн засгийн бүсчилсэн хөгжил эдийн засгийн коридор гэдэг чинь бас яг энэ зам дагуу л байгаа шүү дээ. Гарц суурь, Нарийнсухайт, Шивээ хүрэн гэсэн төмөр замын дагуу байгаа учраас энд оруулчихъя гэсэн агуулга байгаа.

Н.Энхболд: Эдийн засгийн яам, холбогдох яам, Зам, тээврийн яам юу гэж бодож байгаа юм. Эдийн засгийн яамнаас хүн байна уу. Энэ чинь нөгөө замаараа Завхан бусад газруудаар дайрахгүй юу. Шууд Арцсууриас Шивээ хүрэн хүртэл тавих зам байх юм уу. Эсвэл одоо Улиастайгаар дайрах Баянхонгороор ч юм уу хаагуур юм, түүгээр дайрах юм байх юм уу. 3 дугаар микрофон. Тогтох гуайн микрофоныг өгье. Ажлын хэсгийн 3. Битгий дараарай.

Н.Тогтох: Ажлын хэсгийн гишүүн. Тэгэхээр 2016 онд Монгол Улс ОХУ, БНХАУ 3-ын хамтарсан хэлэлцээрээр энэ 3 улсыг холбосон эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр батлагдсан. Тэр дотор Монголыг дайрсан төмөр замын баруун коридорыг байгуулна гэж заасан байдаг. Тэгэхээр одоо энэ хурдны төмөр замаа бол Орос улс Европ тал руугаа харьцаа нь багасаад, Ази тал руугаа эргээж байгаа учраас хурдны төмөр замаа Москва Канзаны одоо төмөр замыг үргэлжлүүлж, Монголоор дайруулан, Хятад улстай холбогдоно гэсэн ийм одоо Евро-Азийн 2 дугаар конгресс дээр Засгийн газар нь илтгэл тавиад Ерөнхийлөгч нь дэмжсэн байдаг юм. Тэгэхээр манайх бол чухам хаагуураа оруулах вэ гэдэг дээр манай тал бас саналаа одоогоос хэлж байх нь зүйтэй юм болов уу. Тэгээд энэ үзэл баримтлалд тусгагдсан байсан тохиолдолд манай Засгийн газрын төлөөлөл, Засгийн газар хоорондоор энийг үндэслээд Монголын хаагуур явуулах вэ. Тэр 3 улсын коридороороо явуулбал зүйтэй юм биш үү гэсэн саналаа одоогоос тавьж байх нэг ёсондоо эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа. Ингэж ойлгож байх л эрхтэй юм шиг. Ажлын хэсэгт бол бодогддог юм.

Н.Энхболд: Тэгэхдээ та төмөр зам ярьчихсан. Энэ дээр чинь авто зам гээд биччихсэн байна шүү дээ. Оныг нь тэгвэл 2050 ондоо багтаагаад, ерөнхийдөө чиглэл гарна. Тэрний дагуу улс хоорондын хэлэлцээр явах юмнууд бас тэртээ

тэргүй гарах нь байна шүү дээ. Манайх бол ерөнхий ийм бодлого гарчихсан. Тэгэхээр цаг хугацааны хувьд бол мэдээж 2, 3 жилийн дотор шийдэхгүй л байх л даа. Ерөнхийдөө хэтийн зорилгод нь оруулаад явж байна. Тэгвэл томъёоллоо тэр гадна дотнын нэр ус, юмнуудыг хасаад Арцсуурь, Шивээ хүрэн боомтынхоо авто замын холболтын асуудлыг зарчмын хувьд дэмжье гээд тэгээд томъёогоо ажлын хэсэг дээр нэг ярих уу. Ийм байдлаар санал хураалт явуулъя. Дэмжье. Нөгөө 2-ыг нь хураагаад хэрэггүй юм уу. 11-ээс 7 дэмжиж, 63,6 хувиар саяын санал дэмжигдлээ.

Үүгээр зарчмын зөрөөтэй саналуудаар санал хурааж дуусаж байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Сүхээ гишүүн танилцуулчих уу. Сүхбаатар гишүүн танилцуулна.

11.23 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд хуулийн төсөл /эцсийн хэлэлцүүлэг/ явуулна.

Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүнээс 2023 оны 6 сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Их Хурлын 2024 оны 5 сарын 31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд ишлэжүүлсэн байгаа.

Байнгын хороо 2024 оны 6 сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж байна.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд ч нэмж тусгаад, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Саяын танилцуулгатай холбогдуулж асуух гишүүн байна уу. Алга байна. Ингэснээр Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгыг нэгдсэн хуралдаанд.

11.26 цаг.

Дараагийн асуудалд орно. Нөгөө бусад байнгын хороо руу орсон гишүүдээ дуудаж байя. Байнгын хорооны гишүүд ээ, манай байнгын хорооны гишүүд бас өнөөдөр 5, 6 Байнгын хороо хуралдаж байгаа. Гишүүд бас бас Төсөв, Аюулгүй байдлын байнгын хороонд оролцоод ирц түр санал хураахад хүрэхгүй болж байгаа учраас түрүүн хэлэлцэхээр тохирсон 2 асуудлаа түр хойшлуулъя.

Ирцээ хэвээр нь хадгалаад энэ ирцээрээ 1.30-аас дахиж хуралдахаар 13.30 хүртэл түр хойшлуулъя. Энэ ирцээрээ явна шүү. 11 хүний бүрэлдэхүүнтэй ирцээрээ.

Тэгээд бусад Байнгын хорооны хуралдаанд орж саналуудаа өгчхөөд

эргээж эндээ цуглаад хурлаа үргэлжлүүлье. Түр завсарлая.

ЗАВСАРЛАГА.

Н.Энхболд: Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны ирцтэй орсон гишүүд танхимдаа ирье. Түр завсарласан байгаа. 13.30-аас хурлаа эхэлнэ гэсэн. Тэгээд хуралдаанаа яаралтай эхлээд, асуудлаа дуусъя.

Зарим Байнгын хороо бас манай Байнгын хорооноос хүмүүс хүлээгээд ирцээ хараад байгаа шүү. Хэдүүлээ хурлаа хурдан дуусгая. Ирцдээ орсон гишүүд хуралдааны танхимд ирээрэй. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 6 сарын 4-ний 4-ний өдрийн хуралдаанаа үргэлжлүүлье. Ирцэд 12 гишүүн байна.

Одоо баталсан хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Учрал сайд хийнэ.

Н.Учрал: Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 28-31-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэж үзлээ.

Мөн ажлын хэсгээс Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын 1 болох Хот тосгоны удирдлагын үйл ажиллагаандаа баримтлах зарчимд “6.1.9. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих” гэсэн санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Н.Энхболд: Ажлын хэсгийн ахлагч Учрал сайдад баярлалаа. Танилцуулгатай холбоод асуух хүн байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна. 3 санал байгаа.

Дэгийн хуульд нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэх явуулахад тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулж оруулах заалттайгаар, чиглэлтэйгээр Байнгын хороонд шилжүүлсэн. Тэгээд үүний дагуу боловсруулсан зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулъя.

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг дагаж орж ирсэн хууль. Санал хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Дэмжье. 6, 6 санал хураахгүйгээр буцаасан. Дахиж Байнгын хороо дээрээ санал хурааж оруулж ир гэсэн. Жаргалмаа гишүүний микрофоныг өгчих.

Б.Жаргалмаа: Байнгын хороо дээр дахиж хэлэлцэх юм бол энэ саналыг дэмжсэнээр дахиад тооцуулъя. Тийм учраас саяын саналыг зарчмын зөрөөтэй саналыг..., уучлаарай, горимын саналаар дахиж хүчингүй болгож тооцож өгнө үү.

Би сая яагаад санал өгөөгүй вэ гэвэл Их Хурлын даргаас чиглэл өгөгдөж байсан. Тийм ээ. Зөвхөн нийслэлийн бүсэд байгаа Тусгай хамгаалалттай газар нутаг буюу Богд уулын ам, Зайсангийн ам гэдэг энэ томъёолол орох уу, үгүй юу гэдэг дээр би эргэлзээд сая саналаа өгөөгүй шүү.

Н.Энхболд: Яг энэ хууль дээр бол тэр угаасаа орохгүй. Орвол тусдаа асуудлаар орох юм. Тэрийг үүний дараа хэдүүлээ ярина. Тэгвэл Жаргалмаа гишүүний гаргасан саналаар саяын санал хураалтын дүнг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулъя гэсэн санал санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хүчингүй боллоо. Одоо түрүүчийн танилцуулсан томъёоллоор дэмжье гэсэн санал хураалт явуулна. Санал хураалт. 11-ээс 7 зөвшөөрч, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал түрүүчийнхтэйгээ холбоотой.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг дэмжье. Санал хураалт. Санал хураалт гишүүд ээ. 11-ээс 7 дэмжиж, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар нэг санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмэх:

2/7 дугаар зүйлийн 7.5-7.7 дахь хэсэг:

“7.5.Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу баригдсан нийтийн номын сан, ахмадын төв, эрүүл мэндийн

анхан шатны тусламж, үйлчилгээ, боловсрол, соёлын болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зориулалттай, олон улсын стандартад нийцсэн барилга, байгууламжид ногдох үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг тухайн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглалтад оруулах шийдвэр гарснаас хойш эхний 5 жилийн хугацаанд чөлөөлж болно.

7.6. Энэ хуулийн 7.5-д заасны дагуу албан татвараас чөлөөлөх үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтыг тухайн хотын Захирагч, салбарын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

7.7. Энэ хуулийн 6.4 дэх хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгөд энэ хуулийн 7.5 дахь хэсэг хамаарахгүй.” Саналыг дэмжье. Санал хураалт. 11-ээс 8 гишүүн, 72,7 хувиар энэ санал дэмжигдлээ.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Нэгдсэн хуралдаанд Оюунчимэг гишүүн танилцуулна.

13.56 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлэг явуулна.

31-ний өдөр явуулсан нэгдсэн хуралдаанаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явах үед Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбогдох зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбоотойгоор шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль,

тогтоомжийн төсөл боловсруулж, Байнгын хороо, нэгдсэн чуулган хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн ийм чиглэл авсан. Үүний дагуу Төр, хувийн хэвшлийн түншилэлийн тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байгаа. Танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал хийнэ. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын нэг болох Хот, тосгоны өөрөө удирдлагын үйл ажиллагаандаа баримтлах зарчимд “6.1.9 төр, хувийн хэвшлийн түншилэлийг дэмжих” зарчмыг нэмэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн Төр, хувийн хэвшлийн түншилэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газраас Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарласан.

Нийслэлийн хэмжээнд нийгмийн суурь хэрэгцээнд шаардлагатай нийтийн зориулалттай дэд бүтцийг бий болгоход эрчим хүч 6.6 их наяд төгрөг, сэргээгдэх эрчим хүч 720 тэрбум төгрөг, дулаан хангамж 1.4 их наяд төгрөг, ариутгах татуургын хангамж 3.3 их наяд төгрөг, аюултай хог хаягдал, хүнсний хангамж их багтаамжтай нийтийн тээвэр зэрэгт 2040 он гэхэд нийт 110.7 их наяд төгрөг

шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоолол гарсан бөгөөд уг зардлыг дан ганц төсвийн эх үүсвэрээр шийдвэрлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах практик хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгараад байна.

Хуулийн төсөлд аймаг, нийслэлд тодорхой салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх эрх хэмжээг бий болгож, улмаар хэрэгжилтийг хангах үүднээс Аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрхэд өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар аймаг, нийслэл нь өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүс нутгийн хөгжлийг дэмжих, улс орны нийгэм, эдийн засагт эерэг үр дүн үзүүлэхийг тодорхой төслүүдийг тодорхойлж, бие даан хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэх болно.

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Н.Энхболд: Учрал сайдад баярлалаа. Одоо хуулийнхаа төслийг бид нар зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүдэд хуулийн төслийг тараачихсан байгаа. Зүйл бүрээр нь хараад тухай тухайн зүйлээр асуулт асууж болно. Ингээд зүйл бүрээр санал хураалт эхэлж явуулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. Алга байна.

2 дугаар зүйл дээр санал, асуулттай гишүүн байна уу. 2 дугаар зүйл Жаргалмаа гишүүн.

Тэгвэл 2 дугаар зүйл дээр санал байхгүй байна.

3 дугаар зүйл дээр санал, асуулт алга.

4 дүгээр зүйл дээр санал, асуулт алга. Зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн зүйлүүд дээр асуулт, санал, зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр нь эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатгаж хэлэлцэх горимын санал оруулж байна. Дэмжье гэсэн гишүүд саналаа өгье. Санал хураалт. Эрдэнэбат гишүүн ээ өгчихсөн үү. 10-аас 6 гишүүн буюу 60 хувь нь горимын саналыг дэмжлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Санал, дүгнэлтийг чуулган дээр Сараа гишүүн.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудаа ярьж дууслаа.

Гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа. Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.01 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ